


**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД**



О.АЛТАНГЭРЭЛ

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөө, жөндөрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилт 4.6-д “Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.” гэж зорилт дэвшүүлж, тус зорилтын хүрэх үр дүнд “Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна.”, “Мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх болсноор нийгмийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, улмаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чадавхыг бүрдүүлсэн байна.” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.6.1-д “нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.” гэж тус тусгасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т эдийн засгийн

ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчноор дэмжих талаар заасан байна. Тухайлбал, дээрх хөтөлбөрийн 1.3-т заасан “Бүсийн төрөлжсөн хөгжлийн зорилт”-ын хүрээнд 1.3.2.4-т “Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төсөл, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг хэрэгжүүлнэ.” гэж, мөн хөтөлбөрийн 4.4-т Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм зорилтын хүрээнд 4.4.2.15-д “Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, үр өгөөжийг дээшлүүлнэ.” гэж тус тус заасан.

Харин сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрүүдийг зохион байгуулалттайгаар зогсоох, саад учруулах, улс орны эдийн засгийн хүчийг доройтуулах, эмх замбараагүй байдлыг бий болгох зэрэг тохиолдол гарсаар байна.

Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд нийт газрын ховор элементийн ислийн 3.1 сая тонны нөөц бүхий нийт 6 орд илрүүлсэн. Энэхүү эрдсийн баялгаараа Монгол Улс дэлхийд эхний 15 дугаар байрт жагсдаг. Хэрэв олборлолтын үйл ажиллагааг эрчимжүүлбэл газрын ховрын экспортоос их хэмжээний орлого олж эдийн засгийг өсгөх, үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой дээрх ордын нэг бол Халзан бүрэгтэй юм.

Гэсэн хэдий ч 2022 онд холбогдох хуулийн этгээд зөвшөөрлийн эрхээ авах үед уг төслийг хэсэг бүлэг хүмүүс эсэргүүцэж, Халзан бүрэгтэй уулыг хөндүүлэхгүй гэж зохион байгуулалттайгаар тус төслийг зогсоох нөхцөл байдалд хүрсэн.

Түүнчлэн олон жилийн хугацаанд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төсөл, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг хэрэгжүүлэх ажлыг зогсоох арга хэмжээг зарим төрийн бус байгууллага, иргэдээс авсан байдаг. Гэтэл уг төслийг зогсоох, саатуулах тусам Монгол Улсын эдийн засаг хохиролтой бөгөөд гадаад орны эрчим хүчний хараат байдалд манай улс хэвээр байна.

Иймд Монгол Улсын эдийн засгийг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий томоохон мега төсөл, хөтөлбөрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, түүний эрх зүйн орчныг дэмжихээс гадна уг төсөл, хөтөлбөрийг зогсоох, царцаах, саатуулах үйл ажиллагааг идэвхтэй явуулж байгаа албан тушаалтан, хуулийн этгээд, хувь хүнд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д заасны дагуу Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байна.

Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн Хорьдугаар бүлэгт заасан Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэгт төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлж байгаа хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг хууль бусаар зогсоох үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэмэлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бодлогын баримт бичигт туссан нийгмийн ач холбогдол бүхий томоохон мега төсөл, хөтөлбөрүүд саадгүй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн мега төслүүд хэрэгжиж эхэлснээр иргэдийн амьжиргаа дээшилж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

---oOo---